



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 657

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймгийн Хэрлэн сумд барьж, ашиглалтад оруулсан нийт 772,231,899.00 (долоон зуун далан хоёр сая хоёр зуун гучин нэгэн мянга найман зуун ерэн есөн) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан kontорын барилгыг Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэст эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.
2. Стандарт хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Дорнод аймгийн стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга Н.Энхболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:
  - 2.1. Үндсэн хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах
  - 2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайландаа тусгах;
  - 2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.
3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА   
Б.ЦЭНГЭЛ  
ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА   
Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дугаар сарын 18.ны өдрийн  
657 дугаар тогтоолын хавсралт



**Стандарт хэмжил зүйн газрын харьяа Дорнод аймгийн  
Стандарт хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгө**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ /төгрөг/
1	Дорнод аймгийн Хэрлэн суманд байрлах Конторын барилга	2020.05.26	1	772,231,899.00  <i>/Долоон зуун далан хоёр сая хоёр зуун гучин нэгэн мянга найман зуун ерэн еc/</i>